

ТАРВАС



Ач холбогдол:



Бөөр ходоодыг цэвэрлэж үрэвсэлээс хамгаалдаг. Ялангуяа шар өвчнөөр өвчилсөн хүмүүс идэхэд амархан гадагшлуулдаг, бөөрний чулуу, шээсний хүчлийн нөлөөгөөр үүсэх талстуудаас сэргийлэх үйлчилгээтэй.

Ургах нөхцөл. Хүйтэнд тэсвэр муутай дулаанд дуртай хүнсний ногоо юм. Тарвасыг говийн бүсэд V/20-VI/10-ны хооронд үржил шим сайтай элсэрлэг, бага зэрэг хайргатай хөрсөнд тарина.

Хөрс боловсруулалт. Талбайн хөрсийг урд жил нь 1 кв.м талбайд 8-9 кг-аар тооцож бүрэн ялзарсан бууцаар бордоод 25-30 см хагалж өвөлжүүлнэ. Хавар цэнэг усалгаа хийсний дараа хөрсийг сайн тэгшилж чулуу хогийг түүж аваад дахин сийрүүлэлт хийсний дараа талбайгаа бэлтгэнэ. Тарвас тарих талбайн хөрс бэлтгэх ажил нилээд өвөрмөц байдаг. Учир нь тарвасны үндэс газрын хөрс рүү гүн тархдаггүй өнгөн хэсгээр нь хажуу талруугаа тархдаг. Мөн хөрсний агаарын дутагдалд эмзэг учир хөрсийг хамарлаж засаад хамар далангийн ирмэг дээгүүр үрийг суулгаж голын сувгаар ус урсгаж услах зорилготойгоор засна. Хөрсийг засаж бэлтгэхдээ 1.4 м өргөнтэйгээр спириал хэлбэрийн суваг гаргаж засна. Зарим ногоочид үүнийг ходоодлон засах арга гэдэг.



Хамар далан
Усалгааны суваг

Үрийг бэлтгэх.

Талбайг бэлтгэх ажилтайгаа давхцуулан үрийг тарилтанд бэлтгэх ажлаа хийж байх хэрэгтэй. Энэ нь хугацаа алдахгүй байх ач холбогдолтой. Тарвасны үрийг бэлтгэхэд дараах үе шаттай ажлуудыг хийнэ. Үүнд:

1. Үрийг зуухны дэргэд 25-30 хэмийн дулаанд 30 орчим хонуулж идэвхжүүлнэ.
2. 25-30 градусын бүлээн усанд 24 цаг дэвтээнэ.
3. 0.03 %-ийн марганцын уусмалд хийж 3 цаг байлгаж ариутгана.
4. Үрийг шүүж аваад бага зэрэг сэврэсний дараа даавуун уутанд хийж овоолсон шар бууцны наранд ээвэр талд 3-4 хоног булна. Ингэхэд үр соёолоход бэлэн болж бүгд задрана.

Тарилт.

Ийнхүү бэлэн болсон үрээ ходоодлон зассан хамар далангийнхаа ирмэг дээгүүр хоорондоо 40см зайтай үүр гаргаж үүр бүхэндээ 1 аяга орчим бүрэн ялзарсан бууц ба багсармал бордоо хийж хутгаад 3ш үр суулгана.

Ээлжлэн тариалалт.



Усалгаа.

Тарихаас өмнө заавал цэнэг усалгаа хийнэ. Цэнэг усалгаагаар хөрс 40-50 см гүн норж хаврын гүний чийгтэй нийлсэн байх ёстой. Цэнэг усалгааны дараа 1-2 хоноход усалгааны ус хөрс рүүгээ нэвчиж ажлын багажинд зууралдахааргүй болсон байдаг. Яг энэ үед хөрсийг боловсруулж засаж бэлтгээд үрээ суулгана. Үр суулгангуут дахин услана. Тохиромжтой хугацаанд тариалсан тарвас 5-7 хоногт бүрэн соёолдог. Тарвасыг соёолсоноос хойш ургалтын хугацаанд 8-12 удаа услана. Тарвасны талбайг нь ходоодлон засдаг учир усалгааг нарийн хэмжих боломжгүй. Иймд хангалттай услахын тулд сувгийг бүрэн дүүргээд бараг хальтал услана. Ингэхэд хамарласан далан нь хажуугаасаа 20см орчим норсон байна.

Усалгааны үе шатууд						
1-2 жинэхэнэ навч гарсан үед	5-7 жинэхэнэ навч гарсан үед	Иш татах үед	Цэцэглэл- тийн үед	Жимс суух үед	Жимс эрчимтэй томрох үед 2 удаа	Эхний түүвэрлэн хураалт хийсний дараа 3-4 удаа

Тайлбар: Иш татах үе гэдэг нь тарвасны анхны ишнээс олон иш салбарлан ургаж эхлэх үеийг хэлнэ.

Усалгааг ихдүүлэх багадуулахын аль аль нь хор уршигтай. Учир нь ихэдсэн үед ургамлын үндэс хөрсөнд муу тархаж тэр хэмжээгээр тэжээлийн бодисын хангамж мууддаг. Ихэдсэн, багадсаныг ажиглаж мэдэж болно. Усалгаа ихэдсэн үед тарвасны навч давжаарч ургалт нь зогсдог. Усалгаа багадсан үед ургалт нь зогсох ба харин навч нь хорчийж хугарамтгай болдог.

Арчилгаа. Зэрлэг устгахаас гадна, цөөлөлт, таналт хийх, нэмэлт үндэс үүсгэх гэсэн өвөрмөц ажиллагаа хийгддэг. Үүнд :

1. Цөөлөлт. 2-3 жинэхэн навч гарсан үед нэг үүрэнд хамгийн сайн ургаж буй нэг ургамлыг үлдээж бусадыг нь сугалан авна.
2. Таналт. Тарвас олон иш татаж ургадаг. Үүнийг танахгүй бол олон жижиг жимс сууж болц нь гүйцдэггүй. Иймд чанартай өндөр ургац авахын тулд зөвхөн 2 иш / зарим хүн зэл гэж ярьдаг. / ургуулж нэг ишин дээр 2-3 эм цэцэг үлдээж бусадыг нь тасална.
3. Нэмэлт үндэс үүсгэх. Тарвасны зэллэн ургаж байгаа ишний үетэй хэсгийг чийгтэй хөрсөнд булна. Ингэхэд булагдсан үенээс үндэс үүсэж тэжээлийн бодисыг нэмж авах боломж бүрдэж ургалт эрчимжинэ.

Хураалт. Тарвас 8 сарын дундуур боловсорч эхлэнэ. Энэ үеэс түүвэрлэн хураана. Няслахад бөглүү дуу гарч байвал боловсорсон гэж үзнэ.